эрсдлийг бууруулах, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох, нийгмийн аюулгүй байдлыг хангахад шинжлэх ухааны ололт амжилт, орчин үеийн техник, технологийг нэвтрүүлэх, олон нийт хамтын ажиллагааг идэвхижүүлэн, шинэ шатанд гаргана гэж үзэж байна.

***П.Батбаяр** -Хууль сахиулахын удирдлагын академийн 821 дүгээр дамжааны суралцагч, онцгой байдлын дэд хурандаа*

## ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ ШУУРХАЙ УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

***Хураангуй.** Онцгой байдлын албанаас аливаа болзошгүй аюулт үзэгдэл, ослын үеийн шуурхай удирдлага, зохицуулалтаар хангах зарим асуудлыг хөндөж тавихыг зорилоо.*

***Түлхүүр** үг. Аюулт үзэгдэл, осол, гамшгийн үеийн шуурхай удирдлага, зохицуулалт.*

Уур амьсгалын өөрчлөлт, дулаарал. хүмүүсийн зохисгүй зарим үйл ажиллагааны нөлөөгөөр үүсэх аюулт үзэгдэл, ослын тоо. учрах хохиролын хэмжээ жилээс жилд манай улсад өсөн нэмэгдэж байгаа нь тоо баримтаас харагдах бөгөөд нэгэнт тохиолдсон аюулт үзэгдэл, ослын үед ард иргэдэд зарлан мэдээлэл хүргэх, эрэн хайх. аврах ажиллагаа явуулах. нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх арга хэмжээг зөв оновчтой, хурдан шуурхай зохион байгуулах нь Онцгой байдлын албаны шуурхай удирдлага, зохицуулалтаас ихээхэн шалтгаалах билээ.

Онцгой байдлын алба нь Гамшгаас хамгаалах тухай хуулиар үндсэн 4 чиг үүргийг хэрэгжүүлэхээр хуульчилсан

1. гамшгаас урьдчилан сэргийлэх
2. гамшигтай тэмцэх, эрэн хайх, аврах
3. гамшгийн хор уршгийг арилгах
4. хойшлуулшгүй сэргээн босгох

Дээрх үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах, онцгой байдлын байгууллага болон гамшгаас хамгаалах удирдлагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахаар Монгол Улсын Их хурлаас ‘Гамшгаас хамаалах тухай" хуулийн шинэчилсэн найруулагыг 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдөр батлан, мөрдөгдөж байна.

Онцгой байдлын байгууллага нь гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж,

мэргэжлийн удирдлагаар хангах тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага ба мэргэжлийн, нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай бөгөөд онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, штаб, бүсийн төв, төв, орон нутгийн онцгой байдлын газар, хэлтэс, анги, салбар, олон улсын болон агаарын эрэн хайх, аврах баг, соёл урлаг, спорт, судалгаа шинжилгээ, сургалт-үйлдвэрлэл. туршилтын болон бусад нэгжтэй, харьяа нэгжийг засаг захиргаа. нутаг дэвсгэр, газар зүйн онцлог, хүн амын нягтрал. аюулт үзэгдэл, ослын давтамж, хамрах цар хүрээг харгалзан Засгийн газрын шийдвэрээр байгуулна[1] гэж тодорхойлсон нь Онцгой байдлын албаны удирдлагын тогтолцоог шинээр боловсруулах, батлуулах, аюулт үзэгдэл, ослын үеийн шуурхай удирдлага, зохицуулалтын үйл ажиллагааг явуулах таатай орчин бүрдсэнээр Монгол Улсын Засгийн газрын тогтоол. Шадар сайдын тушаалаар Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцэд зарим өөрчлөлтийг оруулан ажиллаж байна.

Онцгой байдлын албаны шуурхай удирдлага нь нэгдмэл, нэг хариуцлагын тогтолцоотой байх хэрэгтэй.

Монгол Улсын Засгийн газраас баталсан бүтцээр Онцгой байдлын ерөнхий газрын тэргүүн дэд буюу штабын даргын эрхлэх асуудал хүрээнд Гамшгийн шуурхай удирдлагын газар, Гал түймэртэй тэмцэх газар, Улсын нөөц. хүмүүнлэгийн тусламжийн газар багтсан юм.

Монгол Улсын хэмжээнд тохиолдож болзошгүй аюулт үзэгдэл, ослын болон гамшгийн үеийн шуурхай удирдлага. зохицуулалтыг хангаж ажиллах Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн шуурхай удирдлагын газрын зорилт, чиг үүрэг нь Онцгой байдлын ерөнхий газрын даргын эрхлэх асуудлаар гамшигтай тэмцэх, хор уршгийн арилгах арга ажиллагааг мэргэжлийн шуурхай удирдлага, зохицуулалтаар хангах, гамшгаас хамгаалах улсын албадтай харилцаа хамтын ажиллагааг зохион байгуулж, Улсын Онцгой комиссын ажлын албанд дэмжлэг үзүүлэх. хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах, байгалийн гэнэтийн аюулт үзэгдэл, хүн малын гоц халдварт өвчин, технологийн гаралтай ослын үед шуурхай арга хэмжээг зохион байгуулах, холбоо мэдээллийн техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах, удирдлагыг найдвартай холбоогоор хангах, холбоо зарлан мэдээллийг зохион байгуулах чиг үүргийг,

Мөн Гал түймэртэй тэмцэх газрын зорилт, чиг үүрэг нь Онцгой байдлын ерөнхий газрын даргын эрхлэх асуудлаар галын аюулгүй байдлыг

[1] Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 9 дүгээр бүлгийн 42 дугаар зүйл

хангуулах, обьектын болон ой хээрийн түймэртэй тэмцэх, мэргэжлийн шуурхай удирдлагаар хангах, гал түймэрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх, гал түймрийн эрсдэл, эмзэг байдлыг бууруулах үйл ажиллагааг зохион байгуулах үүргийг,

Мөн Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн газрын зорилт, чиг үүрэг нь улсын нөөцийн бараа, материалын бүрдүүлэлт, хадгалалт, сэлгэлт, шинэчлэлт, тээвэрлэлт, зарцуулалтыг удирдлага зохицуулалтаар хангах, агуулахын аж ахуй, барааны чанар, хадгалалтын технологитой холбогдсон арга хэмжээ, хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах үндсэн үүргийг хүлээж, хандив тусламжийн барааг хүлээн авах, холбогдох шийдвэрийн дагуу хуваарилан олгох ажлыг оновчтой, шуурхай, ил тод зохицуулах үүрэг хүлээнэ' гэж тус тус тодорхойлсон байна.

Дээрх чиг үүргүүдийг харахад Онцгой байдлын байдлын ерөнхий газрын штаб нь аюулт үзэгдэл, ослын үед зарлан мэдээлэл хүргэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагааг шуурхай удирдлага, зохицуулалтаар ханган ажиллах үүргийг давхар хэрэгжүүлэх нь харагдаж байна.

Онцгой байдлын албаны шуурхай удирдлага, зохицуулалт гэдэг нь Онцгой байдлын байгууллагын удирдлагын байр буюу дарга. захирагч /шийдвэр гаргагч/-аас гаргасан гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг удирдлагын хэрэгсэл ашиглан /холбоо мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан/ харьяа анги, салбарууд болон хуулиар гамшгаас хамгаалах талаар үүрэг хүлээсэн төрийн болон төрийн бус байгууллага. аж ахуйн нэгж, ард иргэдэд хүргэж, тэдгээрийн гамшигтай тэмцэх үйл ажиллагааг нэгтгэн, уялдуулан зохицуулж, удирдлагаар хангах үйл ажиллагаа гэж ойлгохоор байна.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын хэмжээнд онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн чиглүүлж, онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга удирдан зохион байгуулж, засаг захиргаа. нутаг дэвсгэрийн нэгжид тухайн шатны Засаг дарга, төрийн болон нутгийн захиргааны байгууллага. хуулийн этгээдэд тэдгээрийн удирдлага зохион байгуулж, хэрэгжүүлнэ[2] гэж тодорхойлсон байна.

Онцгой байдлын албаны шуурхай удирдлага, зохицуулалтаар аюулт үзэгдэл, осол, гамшгийн нөхцөл байдлын тухай мэдээллийг тухай бүр авч.

[1] ОБЕГ. Дунд хугацааны стратеги төлөвлөгөө. 2015-2020.

[2] Гамшгаас хамгаалах тухай хуулийн 5 дугаар бүлгийн 23 дугаар зүйл.

дүн шинжилгээ хийж, тодорхой шийдвэр гарган, хэрэгжилтэнд хяналт тавин, тасралтгүй мэдээлэл цуглуулан, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг шаарддаг.

"Шуурхай удирдлага" гэж төв, орон нутгийн Онцгой байдлын анги, байгууллага. төрийн болон төрийн бус байгууллага, иргэдээс ирсэн гамшгийн нөхцөл байдлын мэдээ, мэдээллийг хүлээн авч дүн шинжилгээ, үнэлгээ хийж. үүссэн болон үүсч болзошгүй нөхцөл байдалд гамшгаас хамгаалах арга хэмжээг шуурхай удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг' хэлнэ гэж тодорхойлсон байна.

Мөн "шуурхай ажиллагаа” гэж Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага, гамшгаас хамгаалах улсын болон орон нутгийн алба, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын гамшгаас хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай мэдээг нэгтгэн цуглуулж, үнэлгээ дүгнэлт хийх, удирдлагыг мэдээллээр тасралтгүй хангах, удирдлагаас гаргасан шийдвэрийг тухайн байгууллагад хүргэж, биелэлтийг зохион байгуулах цогц арга хэмжээ[1] [2] хэмээн заасан.

Дээрх тодорхойлолтыг харьцуулан дүгнэхэд шуурхай удирдлага, зохицуулалт нь шийдвэр гаргах түвшний удирдлагыг үнэн зөв мэдээ, мэдээллээр хангаж, өгөгдсөн үүрэг даалгавар, тушаалыг хэрэгжүүлэх ажлыг гардан зохион байгуулах үйл ажиллагаагаар хангагдана.

Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрэн хайх, аврах, гамшгийн хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох цогц арга хэмжээг түргэн шуурхай, амжилттай хэрэгжүүлэх нь онцгой байдлын албаны шуурхай удирдлага, зохицуулалтын үйл ажиллагаанаас ихээхэн шалтгаалах нь ойлгомжтой билээ.

Монгол Улсад жилд дундажаар 3200-4000 орчим аюулт үзэгдэл, осол тохиолддогийн 90 гаруй хувийг объектын болон ой, хээрийн түймэр, харин үлдсэн 10 орчим хувийг бусад аюулт үзэгдэл, осол ээлдэг байна[3].

Дээрх тоон мэдээллээс харахад манай оронд тохиолдож байсан томоохон хэмжээний гамшгийн үед шуурхай удирдлага, зохицуулалтаар хангаж байсан туршлага, сургамж бага боловч тохиолдож болзошгүй 10 гаруй төрлийн гамшгийн эрсдэл, эмзэг байдлын үнэлгээг орчин үеийн

[1] Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2013 оны 466 дугаар тушаалаар баталсан. Шуурхай удирдлага, зарлан мэдээлэх төвийн ажиллах журам

[2] Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2008 оны 286 дугаар тушаалаар баталса Шуурхай ажиллагааг зохион байгуулах журам.

[3] Монгол Улсад тохиолдсон аюулт үзэгдэл, ослын мэдээний эмхэтгэл. 2014. 2015

дэвшилтэт технологи ашиглан урьдчилан тооцож, хариу арга хэмжээг төлөвлөн, зохицуулан ажиллах ёстой.

Шинээр батлагдсан 'Гамшгаас хамгаалах тухай хууль' үйлчилж эхэлснээр онцгой байдлын албаны шуурхай удирдлага, зохицуулалттай холбоотой 10 гаруй хууль, дүрэм, журам, зааварт судалгаа, дүн шинжилгээ хийж, шинэчлэх асуудал зүй ёсоор тавигдаж байна.

***Ц.Очбадрал*** *-Хууль сахиулахын удирдлагын академийн 821 дүгээр дамжааны суралцагч, онцгой байдлын ахмад*

## ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГАД ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

***Хураангуй.*** *Ахлагч бүрэлдэхүүний сонгон шалгаруулалтыг сайжруулснаар гамшиг, осол, гал түймрийн голомтод Онцгой байдлын албаны бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх чадавх нэмэгдэх болон цаашид тогтвор суурьтай ажиллах нөхцөл бүрдэнэ.*

***Түлхүүр*** *үг. Ахлагч бүрэлдэхүүн, хүний нөөцийн сонгон шалгаруулалт, орон тоо, нөхөн хангалт.*

Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага нь Онцгой байдлын ерөнхий газар, Гамшиг судлалын хүрээлэн, Мэргэжил дээшлүүлэх давтан сургалтын төв, Аврах тусгай анги, Уул уурхайн аврах анги, Хангалт үйлчилгээний анги, төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, Улсын нөөцийн салбар зэрэг 100 гаруй нэгжтэйгээр улсын хэмжээнд гамшиг, осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах. хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үндсэн чиг үүрэгтэй үйл ажиллагаа явуулж байна.

Сүүлийн жилүүдэд улс орны хүн ам, хот суурин газрын хэт төвлөрөл. дэд бүтэц, зам, барилга ихэсч байгаатай уялдан гамшиг, осол, гал түймрийн тоо жил ирэх тутам өсөн нэмэгдэж байгаа боловч Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчийн орон тоо, гал унтраах, аврах ангийн тоо төдийлөн хангалттай нэмэгдэхгүй байна.

Тус байгууллага 2016 оны байдлаар 4121 албан хаагчийн батлагдсан орон тоотой. Үүнээс 3704 төрийн тусгай албан хаагч /1003 офицер, 2701 ахлагч/, 417 төрийн үйлчилгээний албан хаагчийн орон тоотой байна. Офицерийн нөхөн хангалт 93.5 хувь буюу 938, ахлагчийн нөхөн хангалт 89 хувь буюу 2406, төрийн үйлчилгээний албан хаагчийн нөхөн хангалт 99.2 хувь буюу 414 ажилтан байгаа бөгөөд нийт албан хаагчдын нөхөн хангалт 91.1 хувь буюу 3758 албан хаагч үүрэг гүйцэтгэж байна.